



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

БАРУУНБҮРЭН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ ҮНДЭСНИЙ ЭВСЭЛД

2024.08.07 № 0000-2024/14-ЦАТА-НД-42  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ээс ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ” нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

018020621

## Дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-д иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

## Дүгнэлт

“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ” нь 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА